

Улс орнуудын жижиг, дунд аж ахуйн нэгжийг ангилж буй хандлагын судалгаа

Trends of Small and Medium Enterprises Classification in Countries

Д. Лхагвасүрэн¹, Л. Хишигбаяр²

Хураангуй

Дэлхийн аль ч улс орны хувьд аж ахуйн нэгжүүдийн дийлэнх хувийг жижиг, дунд аж ахуйн нэгж (ЖДААН) бүрдүүлж байна. Иймд ЖДААН-ийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэл, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж эдийн засгийг сайжруулахыг улс орнууд зорьж байна. Монгол Улсад Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, ААНОАТ-ын хууль, Нягтлан бодох бүртгэлийн журмаар аж ахуйн нэгжийг ангилдаг. Энэхүү судалгаанд бусад улс орнуудын аж ахуйн нэгжийг хэрхэн ангилж байгааг авч үзсэн. Улс орнууд ажилчдын тоо, борлуулалтын орлого, хөрөнгийн дүн зэрэг шалгуурт үндэслэн аж ахуйн нэгжүүдийг том, дунд, жижиг, бичил хэмээн ангилдаг байна. Цаашид ЖДААН-ийг юунд үндэслэж, яаж ангилбал зохих талаар судалгаа хийх боломжтой.

Түлхүүр үгс: аж ахуйн нэгжийн ангилал, шалгуур, ажилчдын тоо, борлуулалтын орлого

Abstract

Any countries in the world, the majority of enterprises are small and medium enterprises (SMEs) in the World. Accordingly, countries are aiming to increase production and employment and improve the economy by implementing policies to support SMEs. In Mongolia, enterprises are classified according to the Law on Support of Small and Medium Enterprises and Services, the CIT Law, and the Accounting Procedure. This study examines that how companies in other countries are classified. Enterprises are segregated into large, medium, small, and micro based on criteria such as the number of employees, sales revenue, and assets. In the future, it is possible to conduct research on what SMEs are based on and how they should be classified.

Keywords: classification of enterprises, criteria, number of employees, sales revenue

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: dlkhagva@num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: khishigbayar@num.edu.mn

Оршил

ЖДААН нь тухайн улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг тул ЖДААН-ийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэл, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж эдийн засгийг сайжруулах боломжтой. Хятад улс ЖДААН-үүдээ дэмжих хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд бизнест олгож байгаа зээлийн өсөлт нь бусад зээлийн өсөлтөөс багагүй байх, хөнгөлөлтэй зээл олгох гэх мэт олон зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Европод нийт бизнесийн 99%-ийг ЖДААН эзэлдэг. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагаас мэдээлснээр ЖДААН нь нийт ажил эрхлэлтийн 45%, дотоодын нийт бүтээгдэхүүний 33%-ийг бүрдүүлдэг байна. 2002-2012 онд Канадын шинэ ажлын байрны 77%-ийг жижиг дунд бизнес эрхлэгчид бүрдүүлсэн нь бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад ижил түвшний үзүүлэлт юм. Тиймээс ЖДААН-д тулгардаг татварын болон эрхзүйн бэрхшээлүүдийг бууруулахын тулд Засгийн газрууд ЖДААН-ийг дэмжих бодлого хэрэгжүүлсээр байна.

Дэлхийн улс орнууд олон улсын жишиг үзүүлэлтүүдийг харгалзан аж ахуйн нэгжүүдийг ажилчдын тоо, хөрөнгийн хэмжээ, борлуулалтын орлогын хэмжээ зэргээр нь ангилдаг. Монгол улсад ЖДААН-ийг “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийн дагуу ангилж байсан бол 2019 оноос тухайн хууль хүчингүй болсноор “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль”, “ААНОАТ-ын тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн журам”-ийн дагуу ангилах болсон. Энэхүү судалгаанд бусад улс орнууд аж ахуйн нэгжийг хэрхэн ангилж байгааг авч үзсэн. Мөн Монгол улстай орлогын түвшин ойролцоо зарим орнуудыг сонгон тэдгээртэй харьцуулсан.

Сэдвийн судлагдсан байдал

Жижиг болон дунд аж ахуйн нэгжид хамаарах бизнесийг тодорхойлох олон судалгаа хийгдсээр байна. Зарим судалгааны үр дүнгээс дурьдвал:

Senderovitz (2009) олон улсын томоохон таван сэтгүүлд хэвлэгдсэн 124 судалгааны өгүүлээс мэдээлэл цуглуулан ЖДААН-ийг тодорхойлсон байдлыг авч үзэхэд өгүүлүүдийн 40%-д ямар аж ахуйн нэгжүүдийг ЖДААН-д хамруулсан нь тодорхой бус байжээ. Харин судалгааны өгүүллийн 60% нь аж ахуйн нэгжүүдийг борлуулалтын орлогын хэмжээ, ажилчдын тоогоор нь жижиг, дунд, том хэмээн ангилж авч үзжээ.

Fakieh (2018) Саудын Араб улсын нийт аж ахуйн нэгжүүдийн 20%-ийг ЖДААН эзэлж байгаа нь бусад орнуудтай харьцуулахад бага үзүүлэлт боловч ЖДААН-үүдэд мэдээллийн технологийг нэвтрүүлж, ЖДААН-ийн өсөлтийг дэмжих нь зүйтэй юм гэжээ.

Rayman-Bacchus & He (2014) Хятадын баруун өмнөд хэсэгт байрлах керамикийн үйлдвэрлэлийг сонгон ЖДААН-д хамаарах компанийн байгаль орчны болон нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг Боурданы арга хэрэглэн судалсан. Бүтээгдэхүүний чанар, ажилчдын цалинг нэмэгдүүлэх, Засгийн газраас хэрэгжүүлэх бодлого нь ЖДААН-ийн хувьд чухал боловч байгаль орчныг хамгаалах, ажилчдын ажиллах нөхцлийг сайжруулах нь компанийн тогтвортой хөгжилд илүү ач холбогдолтой гэж үзсэн.

Gümüş & Kütahyalı (2017) ЖДААН-үүд нь маркетингийн үйл ажиллагаандаа уламжлалт аргуудаас илүү технологид

суурилсан олон нийтийн цахим сүлжээний аргуудыг ашиглах хэрэгтэй юм гэж үзсэн.

Даариймаа (2016) ЖДААН-үүдийн 80% нь ЖДААН-ийн СТОУС хэрэгжүүлдэггүй гэж дүгнэсэн.

Гантулга (2018) санхүүгийн тайлагналын чанарт компанийн засаглал, мэргэжлийн ёс зүй, хууль эрх зүй, эдийн засаг зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг, санхүүгийн тайлангийн мэдээллийн чанар хангалтгүй байна гэж үзсэн.

ЖДААН-ийг ангилах шалгуур үзүүлэлтүүд

ААН-ийг ангилахдаа тоон болон чанарын шалгуур үзүүлэлтүүдийг ашиглаж болно. Тоон шалгуур үзүүлэлтэнд ажилчдын тоо, үйлдвэрлэлийн хүчин чадал, цалингийн зардлын хэмжээ, ашигласан барааны хэмжээ, борлуулалтын орлого, хөрөнгийн дүн зэрэг хамаардаг бол чанарын шалгуурт бизнесийн шинж чанар, үйл ажиллагаа явуулж буй зах зээл, санхүүгийн чадамж, хөрөнгийн зардлын байдал, мэргэшсэн хүний нөөц зэрэг нь хамаардаг байна (Gümüř & Kütahyalı, 2017).

Европт нийт бизнесийн 99%-ийг ЖДААН

эзэлдэг (EU, 2020). Энд ЖДААН-ийг ажилчдын тоо, эргэлтийн хөрөнгө, балансын дүнгээр тодорхойлдог (Хүснэгт 1).

Европын холбоо 10-аас цөөн ажилтантай бол бичил ААН, 50-иас цөөн ажилтантай бол жижиг ААН, 250-иас цөөн ажилтантай бол дунд ААН гэж ангилдаг бол АНУ-д жижиг, дунд үйлдвэрийн ангилал нь ойлгоход төвөгтэй³ (Хүснэгт 2).

АНУ-д ААН-ийг ажилчдын тоо, орлого, үйл ажиллагаа явуулж байгаа салбараар нь ангилж байна. Тухайлбал, үйлдвэрлэлийн салбарын хувьд ажилчдын тоо нь 500-аас доош байвал ЖДААН-д хамаарагддаг байна. Татварын зорилгоор ЖДААН гэсэн ангилал байхгүй бөгөөд бизнесийг 10 сая доллараас дээш болон доош орлоготой гэж ангилан 2 бүлэгт хуваадаг.

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагаас (OECD) мэдээлснээр ЖДААН нь нийт ажил эрхлэлтийн 45%, ДНБ-ний 33%-ийг бүрдүүлж байна.

2002-2012 онд гэхэд ЖДААН нь Канадын шинэ ажлын байрны 77%-ийг үүсгэсэн

Хүснэгт 1. Европын орнуудын ААН-ийн ангилал

Ангилал	Ажилчдын тоо	Эргэлтийн хөрөнгө (EUR)	Балансын дүн (EUR)
Дунд ААН	< 250	≤ 50 сая	≤ 43 сая
Жижиг ААН	< 50	≤ 10 сая	≤ 10 сая
Бичилт ААН	< 10	≤ 2 сая	≤ 2 сая

Эх сурвалж: https://ec.europa.eu/growth/smes/sme-definition_en

Хүснэгт 2: АНУ-ын ААН-ийн ангилал

	Үйлдвэрлэл ба экспортын бус үйлчилгээ	Экспортын үйлчилгээ		Фермүүд
		Ихэнх нь	Өндөр үнэ цэнэ бүхий ААН (Компьютерийн үйлчилгээ зэрэг)	
Ажилчдын тоо	< 500	< 500	< 500	< 500
Жилийн орлого (USD)		≤ 7 сая	≤ 25 сая	≤ 250,000

Эх сурвалж: Fakhieh (2018)

³ <https://www.investopedia.com/terms/s/smallandmidsizeenterprises>

нь бусад хөгжиж буй орнуудтай ижил хувь хэмжээ байгаа юм. Тиймээс ч ЖДААН-д тулгардаг татварын болон эрхзүйн бэрхшээлүүдийг бууруулахын тулд Засгийн газрууд ЖДААН-ийг дэмжих бодлого хэрэгжүүлсээр байна.

Хятадад “Жижиг, дунд үйлдвэрийг ангилал стандартын журам”-ийн дагуу 2011 онд ЖДААН-ийн ангиллыг гарган мөрдөж байгаа ба салбараас нь хамаарч ангилал нь ялгаатай. Дийлэнх салбарын хувьд ажилчдын тоо, борлуулалтын орлогод суурилан ангилж байхад архитектор болон үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьд борлуулалт болон хөрөнгийн дүнгээс хамааруулан ангилжээ (Хүснэгт 3).

ОХУ-ын хувьд ААН-үүдийг ажилчдын

тоо, борлуулалтын дүнгээр нь ангилжээ (Хүснэгт 4).

Австрали зэрэг орнуудын хувьд ЖДААН-ийг ангилахдаа зөвхөн ажилчдын тоонд үндэслэдэг. Тухайлбал, 200-аас доош ажилчидтай бол бичил, жижиг, дунд ААН-д хамаарах боломжтой (Хүснэгт 5).

2019 оны Дэлхийн банкны судалгаанаас харахад Индонези улс орлогоороо манай улстай ойролцоо ангилагдсан.

Индонези улсын хувьд хөрөнгийн дүн, борлуулалтын дүн, ажилчдын тоог ААН-үүдийг ангилах шалгуур болгон сонгон авдаг (Хүснэгт 6). Улс орон бүр өөрийн орны онцлогийг харгалзан ЖДААН-ийг ангилж байгаа ч ихэнх орнуудын хувьд ЖДААН-ийг ангилахдаа хөрөнгийн хэмжээ, эргэлт, ажилчдын тоо гэсэн ижил

Хүснэгт 3: Хятадын ЖДААН-ийн ангилал

Салбар	Дунд		Бичил		Жижиг	
	Ажилчдын тоо	Орлого, сая юань	Ажилчдын тоо	Орлого, сая юань	Ажилчдын тоо	Орлого, сая юань
ХАА, ферм, загасны аж ахуй	-	5-200	-	0.5-5	-	< 5
Хүнд үйлдвэр	300-1000	20-400	20-300	3-20	< 20	< 3
Бөөний худалдаа	20-200	50-400	5-20	10-50	< 5	< 10
Жижиглэнгийн худалдаа	50-300	5-200	10-50	1-5	< 10	< 1
Тээвэр зуучлал	300-1000	30-300	20-300	2-30	< 20	< 2
Агуулах, аж үйлдвэр	100-200	10-300	20-100	1-10	< 20	< 1
Шуудан	300-1000	20-300	20-300	1-20	< 20	< 1
Барилга, байр	100-300	20-100	10-100	1-20	< 10	< 1
Ресторан/катеринг	100-300	20-100	10-100	1-20	< 10	< 1
Харилцаа холбоо	100-2000	10-1000	10-100	1-10	< 10	< 1
Программ хангамж, мэдээллийн технологи	100-300	10-100	10-100	0.5-10	< 10	< 0.5
Хөрөнгийн менежмент	300-1000	10-50	100-300	5-10	< 100	< 5
Үл хөдлөх хөрөнгийн зууч ба бизнесийн үйлчилгээ	100-300	80-1200	10-100	1-80	< 10	< 1
Бусад	100-300	-	10-100	-	< 10	-
Салбар	Дунд, сая юань		Бичил, сая юань		Жижиг, сая юань	
	Орлого	Нийт хөрөнгө	Орлого	Нийт хөрөнгө	Орлого	Нийт хөрөнгө
Архитектор	60-800	50-800	3-60	3-50	< 3	< 3
Үл хөдлөх хөрөнгө	10-2000	50-100	1-10	20-50	< 1	< 20

Эх сурвалж: <https://www.china-briefing.com>, 2011

Хүснэгт 4: ОХУ-ын ААН-ийн ангилал

Ангилал	Ажилчдын тоо	Орлогын дүн, сая рубль
Дунд ААН	101-250	800-2,000
Жижиг ААН	15-100	120-800
Бичил ААН	< 15	< 120

Эх сурвалж: ОХУ-ын "Жижиг, дунд бизнесийг дэмжих тухай" хуулиас

Хүснэгт 5: Австралийн ААН-ийн ангилал

Ангилал	Ажилчдын тоо
Бичил	1-4
Жижиг	5-19
Дунд	20-199
Том	200-с дээш

Эх сурвалж: Nicolas & Orsmond, 2015; ASBFEO, 2016

Хүснэгт 6: Индонези улсын ААН-ийн ангилал

Ангилал	Хөрөнгийн дүн, сая рупи	Борлуулалтын дүн, сая рупи	Ажилчдын тоо
Бичилт ААН	< 50	< 300	1-4
Жижиг ААН	50 - 500	300 - 2,500	5-9
Дунд ААН	500 - 10,000	2,500 - 50,000	20-99

Эх сурвалж: Maksut нар, 2020

Хүснэгт 7: Зарим орнуудын ЖДААН-ийг ангилж байгаа шалгуур үзүүлэлтүүд

Улс	Хөрөнгийн хэмжээ	Борлуулалтын орлого	Ажилчдын тоо	Салбар	Хөрөнгө оруулалт
Европын холбооны орнууд	+		+		
АНУ		+	+	+	
Хятад	+	+	+	+	
ОХУ		+	+		
Япон			+	+	+
Солонгос		+	+	+	+
Австрали			+		
Индонези	+	+	+		

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл

шалгууруудад үндэслэж ангилдаг байна (Blackburn & Jarvis, 2010).

Хүснэгт 7-оос харахад ААН-үүдийг ангилахдаа борлуулалтын орлого, ажилчдын тоо, салбар, хөрөнгө оруулалт, хөрөнгийн хэмжээг шалгуур үзүүлэлтүүд болгон авч байгаа нь харагдлаа. Сонгосон орнууд бүгд ажилчдын тоог ЖДААН-ийг ангилахад ашиглаж байгаа нь тухайн мэдээллийг гаргахад хялбар байдагтай холбоотой (Ganbold, 2008). Олон орнууд 250-аас доош ажилчидтай ААН-ийг жижиг, дунд гэсэн ангилалд хамааруулан үздэг (Ауадаги нар, 2011). Зарим орны хувьд нэг л үзүүлэлтийг ЖДААН-ийг ангилахад ашиглаж байхад зарим нь 4 үзүүлэлт ашигладаг байна.

Орлогын түвшин ойролцоо орнуудтай харьцуулах нь

2020 оны Дэлхийн банкны судалгаанаас харахад улс орнуудыг орлогын түвшин болон зээлжих чадвараар нь дөрөв (Хүснэгт 8) ангилсан байдаг (Sidek нар, 2020).

Өндөр орлоготой гэсэн бүлэгт АНУ, Япон, Австрали зэрэг 83 орон, дунджаас дээш орлоготой бүлэгт ОХУ, БНХАУ зэрэг 56 орон, дунджаас доош орлоготой бүлэгт Филиппин, Вьетнам, Нигер, Шри-Ланка, Монгол зэрэг 51 орон, бага орлоготой бүлэгт Уганда, Малави, Этиопи зэрэг 31 орон багтжээ.

Филиппин улс ажилчдын тоо, хөрөнгийн

Хүснэгт 8: Улс орнуудыг орлогоор ангилвал

Ангилал	Нэг хүнд ногдох орлого
Өндөр орлоготой	> \$12,536
Дунджаас дээш орлоготой	\$4,046 – \$12,535
Дунджаас доош орлоготой	\$1,036 – \$4,045
Бага орлоготой	< \$1,035

Эх сурвалж: datahelpdesk.worldbank.org/knowledgebase/articles/906519-world-bank-country-and-lendinggroups

Хүснэгт 9: Дунджаас доогуур орлоготой зарим орнуудын ААН-г ангилгах шалгуур

Улс	Хөрөнгийн хэмжээ	Борлуулалтын орлого	Ажилчдын тоо	Хөрөнгө оруулалт/ Капитал
Монгол		+	+	
Филиппин	+		+	
Вьетнам		+	+	+
Нигер	+		+	
Шри-Ланка	+		+	

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл

хэмжээгээр ААН-ийг ангилдаг. Хөрөнгийн дүн ойролцоогоор 70,000-130,000 доллар бол жижиг ААН; 310,000-2,030,000 доллар бол дунд ААН гэж үздэг. Мөн ажилчдын тоо 10-99 бол жижиг, 100-199 бол дунд ААН гэж ангилжээ (Abrugar, 2013).

2018 онд Вьетнамын ЖДААН-ийн хууль батлагдсан. Хуульд зааснаар 200-аас доош ажилчидтай бол ЖДААН-д хамааруулж үзсэн. Мөн ойролцоогоор 4.4 сая доллараас бага капиталын хөрөнгө оруулсан эсвэл 13 сая доллараас бага орлоготой бол ЖДААН-д багтана гэжээ (Das, 2017; Tran нар, 2008).

Нигер улс ажилчдын тоо болон жилийн хөрөнгийн эргэлтээр ААН-ийг ангилдаг. Нигерийн төв банкнаас тодорхойлсноор 11-300 ажилтантай ба жилийн хөрөнгийн эргэлт нь 13,000-1,300,000 доллар бол ЖДААН-д хамааруулна гэжээ (FirstBank, 2018).

Шри Ланка улс салбараар нь жилийн эргэлт болон ажилчдын тоог гарган ААН-ийг ангилдаг. Үйлдвэрлэлийн салбарын ажилчдын тоо 11-300, эсвэл жилийн эргэлт 87,000-4,050,000 доллар бол;

үйлчилгээний салбарын ажилчдын тоо 11-200, эсвэл жилийн эргэлт нь 87,000-4,050,000 доллар бол ЖДААН-д хамаардаг (Athukorala, 2017).

Харин Монгол улсын хувьд ажилчдын тоо 200-аас бага, жилийн орлогын дүн ойролцоогоор 89,000 доллараас бага бол ЖДААН-д хамааруулан үзэж байна.

Монгол Улсын ЖДААН-ийг ангилж буй өнөөгийн байдал

ХХААХҮЯ-аас гаргасан 2019 оны статистик мэдээллээр Монголд 85,761 аж ахуйн нэгж бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 62,263 буюу 72.6 хувь нь жижиг, дунд гэсэн ангилалд хамаарч байна. Жижиг, дунд ангилалд хамаарах аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхлэгчдийн 28% нь ажиллаж, ДНБ-ний 18%-ийг бүрдүүлж байна.

Монгол Улсад ЖДААН-ийг “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-иар ангилдаг байсан бол 2019 оноос тухайн хууль хүчингүй болсноор “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль”-ийн дагуу ангилах болсон. Шинэчилсэн хуулиар жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг

Хүснэгт 10: Монгол улсын ААН-үүдийг ангилсан байдал (MNT)

ААН-ийн ангилал	ААНОАТ хууль		Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль		НББ-ийн тухай хуулийн дагуу ААН-ийн ангилал тогтоох журам	
	Татвар ногдох орлого	Татвар ногдуулах орлого	Борлуулалтын хэмжээ	Ажилчдын тоо	Борлуулалтын хэмжээ	Хөрөнгийн дүн
Бичил	300 сая хүртэл	-	300 сая хүртэл	0-10	1.5 тэрбум хүртэл	500 сая хүртэл
Жижиг	300 сая-1 тэрбум	-	300 сая-1 тэрбум	10-50		
Дунд	1.5 тэрбум дээш	6 тэрбум хүртэл	1-2.5 тэрбум	50-200		
Том	-	6 тэрбумаас дээш	2.5 тэрбум дээш	200-с дээш	1.5 тэрбум дээш	500 саяас дээш

Эх сурвалж: Санхүү, татварын зөвлөгөө судалгааны хүрээлэн

төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, ЖДААН-д үзүүлэх төрийн дэмжлэгийн хамрах хүрээ, хэлбэр, удирдлага, зохицуулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж өгсөн.

2019 онд шинэчлэн найруулж 2020 оноос хэрэгжиж буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын тухай хууль нь шударга татвар төлөгчдийг илүү дэмжих зорилгоор татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлж, шаталсан хувиар татвар төлөх татвар ногдуулах орлогын хэмжээг өсгөсөн, татварын тайлан тушаах давтамжийг аж ахуйн нэгжийн татвар ногдох болон ногдуулах орлоготой холбоотойгоор тогтоосон, татвараас зайлсхийх болон татвараас зугтахын эсрэг зохицуулалт орсон зэрэг нь өмнөх хуулиас онцлог болсон.

“Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг тогтоох журам” 2016 онд батлагдсан. Журмын дагуу борлуулалтын болон хөрөнгийн хэмжээг үндэслэн ААН-ийг ангилж байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг

дэмжих тухай хуулиар 200 хүртэл тооны ажилтантай, 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой бол жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэж тодорхойлсон бол НББ-ийн тухай хуулийн дагуу 1.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой, 500 сая төгрөгөөс дээш хөрөнгө бүхий ААН-ийг том аж ахуйн нэгж байгууллага гэж тодорхойлсон нь борлуулалтын орлого үзүүлэлтийн хувьд ЖДААН-ийн ангилал зөрчилдсөнийг харуулж байна. ААНОАТ-ын хуулиар татвар ногдох орлого нь 300 сая хүртэл бол бичил, 300 саяас 1 тэрбум бол жижиг, татвар ногдуулах орлого нь 1.5 тэрбумаас 6 тэрбум хүртэл бол дунд, 6 тэрбумаас дээш бол том аж ахуйн нэгж гэж ялгаатай байдлаар тодорхойлсон байна.

Ажилчдын тоогоор авч үзвэл 2015-2020 онд нийт ААН-үүдийн 96-98 хувийг бичил болон жижиг ААН эзэлж байна.

Салбараар авч үзвэл 2020 онд Монголын ДНБ-ий 26.5%-ийг үйлчилгээ, 21.9%-ийг уул уурхай, 10.8%-ийг хөдөө аж ахуй, 10.1%-ийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар бүрдүүлж байна. Ажиллах хүчний 24.5% нь хөдөө аж ахуйн салбарт, 14.3% нь бөөний болон жижиглэн худалдааны

Хүснэгт 11: Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн тоо (ажилчдын тоогоор)

Статистик үзүүлэлт	2015-IV	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV	2020-II
1-9	53,226	60,680	66,916	73,941	82,383	85,459
10-19	4,864	5,078	5,173	5,164	5,351	5,268
20-49	3,827	3,979	4,050	4,171	4,195	4,106
50-аас дээш	2,392	2,457	2,458	2,485	2,496	2,415
Бүгд	64,309	72,194	78,597	85,761	94,425	97,248
50-аас доош ажилчидтай байгууллагын хувийн жин	96.28	96.60	96.87	97.10	97.36	97.52

Эх сурвалж: www.1212.mn, Судлаачдын нэгтгэл

салбарт төвлөрсөн байгаа бол бусад салбарт 8% хүртэл хуваарилагдсан байна. Манай улсад аж ахуйн нэгжийг салбараар нь ялгаатай ангилж болох ба ингэснээр ДНБ болон ажиллах хүч бүрдүүлж байгаа гол салбаруудыг дэмжих боломжтой юм.

Дүгнэлт, санал

Дэлхийн улс орнууд нь ЖДААН-ийн ангиллыг борлуулалтын орлогын хэмжээ, ажилчдын тоо, хөрөнгийн хэмжээ, салбар зэргээс нь хамааруулан ялгаатай байдлаар тогтоож байна. Орлогын түвшин ойролцоо бусад орнуудтай харьцуулахад Монгол Улсын жижиг, дундад хамааруулж байгаа бизнесийн борлуулалтын орлогын хэмжээ бага байна. Энэ нь ААН-үүдийн дийлэнх хувийг ЖДААН эзэлж байгаатай холбоотой юм. Зарим орны туршлагыг харгалзан дотоодын нийт бүтээгдэхүүн,

ажиллах хүчийг бүрдүүлж байгаа гол салбаруудыг дэмжин аж ахуйн нэгжийг салбараар нь ялгаатай ангилж болох юм.

ЖДААН-ийн ангилал нь тодорхой байснаар тэдгээрийг төрөлжүүлэн хөгжүүлэх, дэмжих, хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулахад ихээхэн ач холбогдолтой. Манай улсын хувьд ЖДААН-ийн ангиллыг хуулиар зохицуулсан хэдий ч энэхүү ангилал нь санхүүгийн тайлагналын болон татварын зорилгоор ангилсан ангилалтай зөрчилтэй хэвээр байна. Иймээс ЖДААН-ийн ангиллыг бусад улс орны адилаар тодорхой үзүүлэлтүүдээр нэг ижил ангилалд оруулах нь ангиллын ойлгомжгүй, зөрчилдөөнтэй байдлыг арилгах давуу талтай бөгөөд ЖДААН-ийг дэмжиж зах зээлд нэвтрэхэд ихээхэн хөшүүрэг болох юм.

Ашигласан материал

- Abrugar, V. (2013). *Small Businesses in the Philippines*. Retrieved from:
<https://businesstips.ph/small-businesses-in-the-philippines/>
- Athukorala, N. A. R. (2017). *A SME Policy Finally in Sri Lanka*. Retrieved from:
<http://www.ft.lk/rohanthaathukorala/A-SME-policy-finally-in-Sri-Lanka/19-641714>
- Ayyagari, M., Demirguc-Kunt, A., & Maksimovic, V. (2011). Small vs. Young Firms across the World: Contribution to Employment, Job Creation, and Growth. *Policy Research Working Paper No. 5631*.
- Blackburn, R., & Jarvis, R. (2010). The Role of Small and Medium Practices in Providing Business Support to Small- and Medium-sized Enterprises. *International Federation of Accountants - Information Paper*.
- Business Support Office-Armenia (2018). *SMEs in Armenia's Economy 2017*.
- China Briefing (2011). *China Issues Classification Standards for SMEs*.
- Das, K. (2017). *Facilitating SME Growth in Vietnam*. Retrieved from:
<http://www.vietnam-briefing.com/news/facilitating-sme-growth-vietnam.html/>
- Díaz Soriano, M. E. & de los Santos, A. V. (2013). *The identification of Micro, Small to Medium-sized Enterprises through the National Household Survey of Multiple Purposes*.
- EU (2020). *User Guide to the SME Definition*.
- EU Publications. (2012). *Evaluation of the SME definition*.
- European Investment Bank (2013). *Small and Medium Entrepreneurship in Russia*.
- European Investment Bank (2019). *Small and Medium Entrepreneurship in Russia*.
- Fakieh, B. (2018). SMEs Research: The Continuous Need to Explore the ICT Potential. *The 32nd IBIMA Conference*, Seville, Spain.
- FirstBank. (2020). About SMEConnect, Retrieved from:
<https://www.firstbanknigeria.com/business-banking/smeconnect/about>
- Ganbold, B. (2008). *Improving Access to Finance for SME: International Good Experiences and Lessons for Mongolia*. No 438. Tokyo, Japan.
- Gümüş, N., & Kütahyalı, D. N. (2017). Perceptions of Social Media by Small and Medium Enterprises (SMEs) in Turkey. *International Journal of Business and Information*, 12(2), 123-148.
- Maksum, I. R., Rahayu, A. Y. S., & Kusumawardhani, D. (2020). A Social Enterprise Approach to Empowering Micro, Small and Medium Enterprises (SMEs) in Indonesia. *Journal of Open Innovation: Technology, Market, and Complexity*, 6(3), 1-17.
- OECD (2020). *Financing SMEs and Entrepreneurs 2020: An OECD Scoreboard*.

Rayman-Bacchus, L., & He, Z. (2014). Assessing Clustered SME Practice Towards Environmental and Social Impact: A Bourdieusian Approach. *International Journal of Innovation and Sustainable Development*, 8(2), 167-189.

Senderovitz, M. (2009). *How are SMEs Defined in Current Research?*

Sidek, S., Rosli, M. M., Hasbolah, H., & Khadri, N. A. M. (2020). An Overview on Criteria of Small and Medium Enterprises Across the Economies: A Random Selection of Countries. *Journal of Critical Reviews*, 7(14), 1312-1321.

Tran, T. C., Le, X. S., & Nguyen, K. A. (2008). Vietnam's Small and Medium Sized Enterprises Development: Characteristics, Constraints and Policy Recommendations, in Lim, H. (ed.), *SME in Asia and Globalization*, ERIA Research Project Report 2007-5, 323- 364.

World Bank Group & Development Research Center of the State Council and the People's Republic of China (2019). *Innovative China*.

Гантулга, Г. (2018). *Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг үнэлэх нь*. Докторын диссертаци, УБ хот

Даариймаа, Р. (2016). *Жижиг, дунд аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийг боловсронгуй болгох нь*. Докторын диссертаци, УБ хот.

[https://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_GDP_\(PPP\)_per_capita](https://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_GDP_(PPP)_per_capita)